



**№5.4.ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ, ДУЛААНЫ
СТАНЦЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН
ХУУДАС**

Хяналтын байгууллага:

Шалгуулагч этгээдийн нэр:

Объектын нэр:

Регистрийн дугаар:

Хяналт шалгалт хийсэн огноо: .../.../...

Шаардлага хангасан асуултын тоо:

Хууль сахин мөрдөлтийн хувь:

Шаардлага хангаагүй нийт оноо:

Эрсдэл үүсэх магадлалын хувь:

Эрсдэл үүсэх магадлал

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын нэр, зүйл, заалт	Асуултууд	Батлагдсан оноо		Авсан оноо
			Шаардлага хангасан	Шаардлага хангаагүй	
1	2	3	4	5	
I. Дулааны цахилгаан станц, дулааны станцын ашиглалтын зохион байгуулалт, горим ажиллагаа			0	340	0
1	Эрчим хүчний тухай хуулийн 29.1.1	Батлагдсан горимын дагуу хэрэглэгчдийг эрчим хүчээр тасралтгүй, найдвартай хангадаг	0	50	
2	“Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 38.2	Үндсэн тоноглол болон хурц уур, тэжээлийн усны шугамын ашиглалтын хугацаа дуусаагүй	0	50	
3	2007 оны 53 дугаар тушаалаар батлагдсан “Түлш, эрчим хүчний салбарын үйлдвэр, компаниудын аюулгүй, найдвартай ажиллагааг хангахад шаардлагатай түлш болон тоног төхөөрөмж, сэлбэгийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх журам”	Аюулгүйн нөөц сэлбэг материалын жагсаалтыг эрх бүхий байгууллагаар батлуулж, аюулгүйн нөөцийг бүрдүүлсэн	0	50	
4	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13.2	Өмнөх шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгасан	0	10	

5	“Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 38.2, ЭХТТБТАД-ийн 1.6.5	Үндсэн ба туслах тоноглол, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ээлжит их болон урсгал засвар, туршилт, тохируулгыг хугацаанд нь чанартай хийж, өвөлжилтийн бэлтгэлийг хангуулсан, турбин, зуух, генераторын их засварыг 4 жилд 1 ээс доошгүй удаа хийсэн	0	10	
6	“УБУХЗТААД”, “ДСТААД”, “УБУШХТААД”-ийн холбогдох заалтууд	Зуух, даралтат сав, шугам хоолойн техникийн магадлалыг цаг хугацаанд нь гүйцэтгэж, мэргэжлийн хяналтын байгууллагаас ашиглах зөвшөөрөл авсан	0	20	
7	“Эрчим хүчний үйлдвэрт гарсан аваари, ослыг судлан бүртгэх журам”-ын 4.1	Сүүлийн 1 жилийн хугацаанд аваари, саатал, зогсолт гараагүй	0	10	
8	УБУХЗТААД 9.1.1	Гарсан аваар саатлыг мэргэжлийн хяналтын байгууллагад яаралтай мэдэгддэг	0	10	
9	Эрчим хүчний тухай хуулийн 33.1	Эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг тогтоолгож, мөрдөлтийг хангуулдаг	0	10	
10	“УБУХЗТААД”, “ДСТААД”, “УБУШХТААД”-ийн холбогдох заалтууд	Үндсэн ба туслах тоноглол, шугам хоолойн угсралт засварын ажлын баримт бичиг, акт, гагнуурын ажлын акт, формулярыг бүрдүүлсэн	0	5	
11	“ДХТТБДШСТАД”-ийн 1.3.1	ИТА, ашиглалт, засварын ажилчид сургалтад хамрагдаж мэргэжлийн үнэмлэх авсан	0	5	
12	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрмийн 1.3.19 дэх заалт	Ерөнхий инженерийн баталсан сэдвийн дагуу аваари эсэргүүцэх дасгал, галын аюулыг эсэргүүцэх ба урьдчилан сэргийлэх дасгал, ослоос сэргийлэх ба анхны тусламж үзүүлэх дасгалыг тогтмол хийдэг, хангалтгүй дүн авсан хүмүүсээс ТАД, ААД, ГАУСД болон үйлдвэрлэлийн ба албан тушаал /ажлын байр/-ын зааврын мэдлэгээр ээлжит бус шалгалт авдаг	0	5	
13	Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрмийн 1.7.2 дахь заалт	Үндсэн ба туслах тоноглол, тоног төхөөрөмжийн ашиглалт аюулгүй ажиллагааны заавар болон ажилтнуудын ажил үүргийн заавар, схемийг баталгаажуулж заавал байх ажлын байруудад байрлуулсан	0	5	
14	Эрчим хүчний тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх заалт	Хэрэглэгчдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг бүрэн барагдуулсан	0	5	

15	ЭХТТБТАД-ийн 1.1.2	Дулааны цахилгаан станц, дулааны станц нь бие даасан шуурхай удирдлагын нэгжтэй	0	5	
16	ЭХТТБТАД-ийн 1.1.5	Станцад тоног төхөөрөмж, барилга байгууламжуудын ашиглалтын ажил үүргүүдийг үйлдвэрлэлийн нэгжүүдэд /цех, салбар, алба, хэсэг, лаборатори г.м/ хуваарьлан хариуцуулсан	0	5	
17	ЭХТТБТАД-ийн 1.1.6	Ажиллагсдыг хөдөлмөрийн ажлын ээлжүүдээр зохион байгуулсан	0	5	
18	ЭХТТБТАД-ийн 1.3.1	Инженер техникийн ажилтан, ажилчид нь эрхэлсэн албан тушаалдаа тохирох боловсрол ба мэргэжил эзэмшсэн	0	5	
19	ЭХТТБТАД-ийн 1.3.2, 1.3.10	Эрчим хүчний үйлдвэр, байгууллагын зүгээс ажиллагсадаас мэдлэгийн анхны, ээлжит, ээлжит бус шалгалтуудыг авдаг	0	5	
20	ЭХТТБТАД-ийн 1.5.1	Тоног төхөөрөмж, барилга байгууламжийн бүрэн бүтэн, ашиглалтын аюулгүй байдлыг хариуцагчид, техник технологийн хяналт хариуцагчийг томилон, үүрэг хариуцлагыг нь албан тушаал /ажлын байрны тодорхойлолт/-ын зааварт нь тусган баталсан	0	5	
21	ЭХТТБТАД-ийн 1.5.6	Эрчим хүчний үйлдвэр нь дотоод хяналтын нэгжтэй, түүний инженер байцаагч нь өөрийн ажил үүргийг техник ашиглалтын дүрмийн дагуу гүйцэтгэдэг	0	20	
22	ЭХТТБТАД-ийн 1.6.9	Дунд ба их засвараас гарч байгаа тоног төхөөрөмжийг 48-72 цаг ачаалалтайгаар ажиллуулж туршилт хийсэн	0	5	
23	ЭХТТБТАД-ийн 1.6.4	Тоног төхөөрөмж, барилга байгууламжид гарсан эвдрэл гэмтэл, авари саатал, тасралт, технологийн зөрчил зэргийг судлан бүртгэж, түүнийг арилгах талаар техникийн бодлого боловсруулан арга хэмжээ авдаг	0	5	
24	ЭХТТБТАД-ийн 1.7.3	Үндсэн ба туслах тоноглолуудад техникийн үзүүлэлттэй пайзыг байрлуулсан, шугам хоолой, кабелийн шиний систем, секцүүд, хаалт арматурт хаяг, дугаарлалт хийсэн	0	5	
25	ЭХТТБТАД-ийн 1.7.18	Станц нь зарлан мэдээлэх, онцгой үед шуурхай мэдээлэл өгөх системээр тоноглогдсон	0	5	

26	ЭХТТБТАД-ийн 1.8.1	Станц нь технологийн үйл ажиллагааг удирдах автомат системээр тоноглогдсон, ажиллагаа хэвийн	0	5	
27	ЭХТТБТАД-ийн 1.11.1	Станц нь гал унтраах усны шугам сүлжээ, галын дохиоллын ба гал унтраах байгууламжаар тоноглогдсон	0	5	
28	ЭХТТБТАД-ийн 4.7	Эрчим хүчний үйлдвэр байгууллага нь химийн болон хэмжилзүйн лабораторитай	0	5	
29	ЭХТТБТАД-ийн 1.12.7	Хүрээлэн байгаа орчныг бохирдуулах бодисын ялгаралт ба бусад физик нөлөөллийн үзүүлэлтүүдэд хяналт тавих байнгын ажиллагаатай автомат хэмжүүрүүдтэй, эсвэл үе үе хэмжилт хийх багаж төхөөрөмжтэй	0	5	
30	ЭХТТБТАД-ийн 2.2	Үйлдвэрлэлийн барилга байгууламж, хөргөлтийн цамхаг, утааны янданд техник ашиглалтын дүрэмд заасан хугацаанд техникийн магадлал хийсэн	0	5	
II. Тоноглол, тоног төхөөрөмжүүд			0	940	0
Зуух					
31	УБУХЗТААД-ийн 2.1.1	Зуух, шугам хоолой, тоног төхөөрөмжийн иж бүрэн батлагдсан зураг төсөлтэй	0	20	
32	УБУХЗТААД-ийн 10.1.1	Зуухыг улсын бүртгэлд хамруулж, ашиглах зөвшөөрөл авсан	0	20	
33	УБУХЗТААД-ийн 4.1.1, 5.3.7	Зуухны угсралт засварын ажлын баримт бичиг, акт, гагнуурын ажлын акт, формулярыг бүрдүүлсэн	0	5	
34	УБУХЗТААД-ийн 9.1.1	Зуухны ашиглалт, аюулгүй ажиллагааны хяналт хариуцагчийг тушаалаар томилсон, өөрийн үүргээ биелүүлэн ажилладаг	0	5	
35	УБУХЗТААД-ийн 5.16.1	Зуухны техникийн паспорттай, түүний хөтлөлт баяжилт хийдэг	0	5	
36	УБУХЗТААД-ийн 9.1.1	Зуух, түүний бусад тоног төхөөрөмжийн ашиглалт аюулгүй ажиллагааны батлагдаж хянагдсан заавартай	0	5	
37	Эрчим хүчний тухай хуулийн 20.2	Зуухыг угсрах, засварлахдаа эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар гүйцэтгүүлсэн	0	20	
38	УБУХЗТААД-ийн 6.1.4	Дулааны тэлэлтийн реперүүд суурилагдсан, түүний ажиллагаа хэвийн	0	5	
39	УБУХЗТААД-ийн 3.3.3	Ам, нээлхий, таг, тэдгээрийн бэхэлгээ бүрэн бүтэн	0	5	

40	УБУХЗТААД-ийн 3.1.6	Зуухны өрлөг дулаалга эвдрэл гэмтэлгүй, өрлөгийн гадаргуу дээрх температур 45 С-ээс ихгүй	0	5	
41	ЭХТТБТАД-ийн 4.3.33	Зуух ба хийн хөндийн бүрхүүл гадаргуугийн нягтыг сард 1 удаа үзэж, агаар соролтод хяналт тавьдаг	0	5	
42	ЭХТТБТАД-ийн 4.3.35	Зуухыг бэлтгэлд буюу засварт гаргахдаа зуух ба калориферүүдийн халах гадаргууг "Дулааны тоноглолыг битүүмжлэх /консервац хийх/ заавар"-ын дагуу битүүмжилсэн	0	5	
43	ЭХТТБТАД-ийн 4.3.36	Зуухыг галлах, зогсоосны дараа халах гадаргуугийн дотор талыг усаар эсвэл химийн аргаар цэвэрлэсэн	0	5	
44	ЭХТТБТАД-ийн 4.3.43	Мазутаар асаадаг зуухны мазут аж ахуй болон мазут дамжуулах хоолойн схем нь ажиллагаанд бэлэн	0	5	
45	УБУХЗТААД-ийн 6.2.19	Хамгаалах хавхлагад тохируулга хийж, албадан онгойлгож шалгадаг, албадан онгойлгох замаар шалгах тоног хэрэгсэлтэй	0	10	
46	УБУХЗТААД-ийн 6.2.21	Хамгаалах хавхлаг нь түүнийг ажиллах үед ажиллагсдыг түлэгдэлтээс хамгаалсан уур гадагш гаргах шугам хоолойтой	0	5	
47	УБУХЗТААД-ийн 6.4.1	Зууханд түүний зураг төсөлд заагдсан манометр, термометр, усны түвшний хэмжүүр тавигдсан, түүний ажиллагаа хэвийн	0	10	
48	УБУХЗТААД-ийн 9.3.2	Ашиглалтын үед хянах, хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг зуухны дүрэмд заасан хугацаанд шалгадаг, мөн 12 сард хийгдэх ээлжит шалгалт хийгдэж лац ломбо тавьсан	0	5	
49	УБУХЗТААД-ийн 6.8.6	Тэжээлийн усны насосны ажиллагаа хэвийн, бэлтгэл насостай	0	10	
50	УБУХЗТААД-ийн 7.1.1	Зуухыг барилгын норм, дүрмийн шаардлага хангасан зориулалтын байранд байрлуулсан	0	10	
51	УБУХЗТААД-ийн 7.2.1	Зуухны ажлын байр нь байнгын болон аваарийн гэрэлтүүлэгтэй, ажиллагаа хэвийн	0	5	
52	УБУХЗТААД-ийн 7.4	Байнгын шат тавцан нь зураг төсөл, дүрэмд заасан шаардлагыг хангасан	0	5	

53	УБУХЗТААД-ийн 7.5.1	Хатуу түлшээр ажилладаг 2 тн/цагаас дээш хүчин чадалтай уурын зууханд зуух, галын хотолд түлш өгөх ажиллагааг механижуулсан	0	10	
54	УБУХЗТААД-ийн 7.5.1	Нийт зуухнаас 150 кг/ц ба түүнээс их хэмжээний үнс шаарга гаргадаг зуухны газрын үнс шааргыг механижуулсан, түүний ажиллагаа хэвийн	0	10	
55	УБУХЗТААД-ийн 9.1.1	Зуухны ашиглалттай холбоотой ажилтнуудыг тогтоосон шаардлагатай орон тоогоор нь бүрдүүлсэн	0	10	
56	УБУХЗТААД-ийн 9.5.1	Зууханд төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх засварыг батлагдсан графикын дагуу цаг тухайд нь хийж гүйцэтгэсэн	0	20	
57	УБУХЗТААД-ийн 10.3.4	Шаталтын горим тохируулсан	0	10	
58	УБУХЗТААД-ийн 6.7.1	Хориг дохиолол, автоматжуулалтын системээр бүрэн тоногдсон, ажиллагаа хэвийн	0	10	
59	УБУХЗТААД-ийн 10.3.5	Тохируулга зүгшрүүлэлтийн ажлын төгсгөлд зуух, туслах тоноглолыг 72 цагийн туршид хэвийн ачаалалтай явуулж, бүрэн туршилт хийсэн	0	10	
Турбины төхөөрөмж					
60	ЭХТТБТАД-ийн 4.4.2	Турбины автомат тохируулгын систем нь дулааны ачааллыг өгөгдсөн хэмжээнд тогтвортой барьж чаддаг ба алгуур өөрчлөх боломжийг хангасан, турбин ачаалалгүй үед роторын эргэлтийг тогтвортой барьж чаддаг болон явуулах үеийн хэвийн уурын параметруудэд хурдыг аажмаар өөрчилж чаддаг, турбины ачаалал гэнэт бүрэн хаяхад турбины роторын эргэлтийг аюулгүйн автомат ажиллах хэмжээнд хүртэл нэмэгдүүлэлгүй барьдаг	0	10	
61	ЭХТТБТАД-ийн 4.4	Турбины их бие, ротор, ажлын хүрээнд хэв гажилт, доргио чичиргээ илрээгүй	0	10	
62	ЭХТТБТАД-ийн 4.4.14	Турбины тос хангамжийн системийн ажиллагаа хэвийн, тосны чанар ба температурын горимыг барьдаг, тосны шүүрэлт гоожилтгүй	0	5	
63	ЭХТТБТАД-ийн 4.4.19	Турбины конденсаторын бохирдолыг хими физикийн аргаар цэвэрлэдэг	0	5	
Технологийн процессын удирдлагын систем					

64	ЭХТТБТАД-ийн 4.6	Станц нь технологийн процессын удирдлагын системээр тоноглогдсон, ажиллагаа хэвийн	0	20	
Ус бэлтгэлийн төхөөрөмж, усны химийн горим					
65	ЭХТТБТАД-ийн 4.7.3	Ус бэлтгэл, турбины болон бохирдсон конденсатыг цэвэрлэх байгууламж, усны нэмэлт боловсруулалт хийх төхөөрөмжөөр тоноглогдсон, ажиллагаа хэвийн	0	20	
66	ЭХТТБТАД-ийн 4.7.6	Ус бэлтгэлийн тоног төхөөрөмжийн засвар шинэчлэлийн ажлыг цаг тухайд нь гүйцэтгэсэн	0	5	
67	ЭХТТБТАД-ийн 4.7.14	Уур, усны чанар нь техник ашиглалтын дүрмийн шаардлагыг хангасан, усны чанарт тогтмол хяналт тавьж ажилладаг	0	10	
Үнс барих ба үнс зайлуулах байгууламж					
68	ЭХТТБТАД-ийн 4.9.1	Үнс барих болон үнс зайлуулах систем, төхөөрөмжөөр тоноглогдсон, ажиллагаа хэвийн	0	20	
69	ЭХТТБТАД-ийн 4.9.15	Үнс зайлуулах системийн шугам тоноглолууд нь гоожилтгүй нягт, суваг, хоолойн өнгөлгөө хучилт нь бүрэн бүтэн	0	5	
70	ЭХТТБТАД-ийн 4.9.29	Үнсэн сан дүүрээгүй, далан хаалт нь эвдрэл гэмтэлгүй	0	10	
Даралтат сав					
71	ДСТААД-ийн 1.2.1	Даралтат сав, шугам хоолой, тоног төхөөрөмжийн иж бүрэн батлагдсан зураг төсөлтэй	0	20	
72	Эрчим хүчний тухай хуулийн 20.2	Даралтат савыг үйлдвэрлэх, угсрах, засварлахдаа эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй байгуулагаар гүйцэтгүүлсэн	0	10	
73	ДСТААД-ийн 6.4.1	Даралтат савыг улсын бүртгэлд хамруулж, ашиглах зөвшөөрөл авсан	0	20	
74	ДСТААД-ийн 7.1.1	Даралтат савны ашиглалт, аюулгүй ажиллагааны хяналт хариуцагчийг тушаалаар томилсон	0	5	
75	ДСТААД-ийн 3.5	Даралтат сав, шугам хоолойг угсарч суурилуулсан болон туршиж шалгасан тухай акт, баримт бичиг бүрдүүлсэн	0	10	
76	ДСТААД-ийн 6.2.4	Даралтат савны техникийн паспорттай, түүний хөтлөлт баяжилт хийдэг	0	5	
77	ДСТААД-ийн 7.1.2, 7.2.6	Даралтат савны ашиглалт аюулгүй ажиллагааны зааврыг боловсруулж хянуулж батлуулсан	0	10	
78	ДСТААД-ийн 7.2.1	Даралтат савтай харьцаж ажилладаг ИТА, ажиллагсад мэргэжлийн сургалтад хамрагдаж, эрх авсан	0	10	

79	ДСТААД-ийн 6.4.1	Даралтат савны техникийн магадлалыг цаг хугацаанд нь хийлгэсэн	0	20	
80	ДСТААД-ийн 4.5.1, 6.3.4	Даралтат саванд үл эвдэх аргаар сорилт, туршилт хийсэн	0	20	
81	ДСТААД-ийн 6.3.15	Даралтат сав, шугам хоолойн их бие, гагнаасан холболт, үндсэн металд ан цав, гоожилт, хөлрөлт, гэмтэл согог илрээгүй	0	10	
82	ДСТААД-ийн 5.1.1	Даралтат сав нь хаах, хамгаалах, хянах хэмжих хэрэгслүүдээр бүрэн тоноглогдсон	0	10	
83	ДСТААД-ийн 5.5.9	Хамгаалах хавхлагыг туршиж тохируулж, акт үйлдсэн	0	10	
84	ДСТААД-ийн 5.3.11	Хянах хэмжих хэрэгслийг баталгаажуулсан	0	10	
85	ДСТААД-ийн 6.1.1	Даралтат савыг хүмүүс олноор цуглардаггүй ил задгай талбайд буюу зориулалтын тусгай байранд байрлуулсан	0	20	
86	"Хийн аж ахуйн аюулгүй ажиллагааны дүрэм"-ийн 3.11.1 заалт	Шатамхай буюу шахсан хийн даралтат сав байрлаж буй өрөө тасалгаанд халаах хэрэгслээс 2 м-ээс доошгүй зайтай, цахилгаан тоног төхөөрөмж нь тэсрэлтийн хамгаалалттай	0	10	
Шугам хоолой					
87	УБУШХТААД-ийн 2.1.1	Шугам хоолой, тоног төхөөрөмжийн иж бүрэн батлагдсан зураг төсөлтэй	0	25	
88	Эрчим хүчний тухай хуулийн 20.2	Шугам хоолойг угсрах, засварлахдаа эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар гүйцэтгүүлсэн	0	20	
89	УБУШХТААД-ийн 1.4.1	Угсралт, засварын ажилд хэрэглэсэн материал, хагас боловсруулсан бүтээгдэхүүн нь дүрмийн шаардлагад нийцсэн	0	20	
90	УБУШХТААД-ийн 4.4.1	Шугам хоолойд үл эвдэх аргаар сорилт, туршилт хийсэн	0	20	
91	УБУШХТААД-ийн 6.3.3	Шугам хоолойн угсралт засварын ажлын баримт бичиг, акт, гагнуурын ажлын акт, формулярыг бүрдүүлсэн	0	5	
92	УБУШХТААД-ийн 5.3.1	Шугам хоолойг улсын бүртгэлд хамруулж, ашиглах зөвшөөрөл авсан /Улсын бүртгэлтэй шугам хоолойд хамаарна/	0	20	
93	УБУШХТААД-ийн 6.1.1	Шугам хоолойн ашиглалт, аюулгүй ажиллагааны хяналт хариуцагчийг тушаалаар томилсон, өөрийн үүргээ биелүүлэн ажилладаг	0	5	

94	УБУШХТААД-ийн 5.1.1	Шугам хоолойн техникийн паспорттай, түүний хөтлөлт баяжилт хийдэг	0	5	
95	УБУШХТААД-ийн 6.1.1	Шугам хоолойн ашиглалт аюулгүй ажиллагааны заавартай	0	10	
96	УБУШХТААД-ийн 6.1.1	Шугам хоолойн угсралт, засвар, ашиглалтын ажилчдыг мэргэжлийн сургалтад хамруулж үнэмлэхжүүлсэн	0	10	
97	УБУШХТААД-ийн 5.2.12	Шугам хоолойг ашиглах тооцоолсон хугацаа дуусаагүй	0	25	
98	УБУШХТААД-ийн 7.2	Шугам хоолойн өнгө будаг, бүс, хаяг бичилт нь дүрмийн шаардлагад тохирсон	0	5	
99	УБУШХТААД-ийн 2.4.3	Шугам хоолойн хонгил, сувгийн өндөр, шугам хоолойн хоорондох зай хэмжээ нь норм, дүрмийн шаардлага хангасан	0	5	
100	УБУШХТААД-ийн 2.4.5	Газар доорх шугам хоолойг үйлчлэхэд зориулсан худаг нь шат буюу дөрөвч бүхий 2-оос доошгүй ам нээлхитэй	0	5	
101	УБУШХТААД-ийн 2.1.7	Шугам хоолой болон даацын металл хийц нь зэврэлтээс хамгаалагдсан	0	5	
102	УБУШХТААД-ийн 2.1.8	Шугам хоолойн 55 хэмээс дээш температуртай хэсгүүдийг дулаалсан	0	5	
103	УБУШХТААД-ийн 3.1.1	Шугам хоолойн материалын чанар нь дүрмийн шаардлагыг хангасан	0	20	
104	УБУШХТААД-ийн 4.2.1	Шугам хоолойд хийсэн гагнуурын ажлын чанар, технологи нь дүрмийн шаардлагыг хангасан	0	10	
105	УБУШХТААД-ийн 2.8.2	Хамгаалах хавхлагын ажиллагаа хэвийн, туршилт, тохируулга хийсэн	0	10	
106	УБУШХТААД-ийн 2.8.3	Хамгаалах хавхлаг нь түүнийг ажиллах үед ажиллагсдыг түлэгдэлтээс хамгаалсан ажлын биеийг гадагш гаргах шугам хоолойтой	0	5	
107	УБУШХТААД-ийн 2.5.2	Дулааны тэлэлт хянах ба тулгуур дүүжин бэхэлгээнд ажиглалт хийх шилжилт заагч хэмжүүр суурилагдсан, ажиллагаа хэвийн	0	10	
108	УБУШХТААД-ийн 6.2.6	Хянах хэмжих хэрэгслээр бүрэн тоноглогдсон, 12 сард хийгдэх ээлжит шалгалтыг хийж, лац ломбо тавьсан	0	10	
109	УБУШХТААД-ийн 2.6.1	Шугам хоолойн даацын хийц, түүний тулгуур, дүүжин бэхэлгээнд хэмжилт, шалгалт хийсэн	0	5	
110	УБУШХТААД-ийн 5.2	Шугам хоолойд гадаад, дотоод үзлэг цаг хугацаанд нь хийлгэсэн	0	20	

111	УБУШХТААД-ийн 5.2	Шугам хоолойд усан сорилт хийгдсэн, усан сорилтод тэнцсэн	0	15	
Түлш дамжуулах					
112	ЭХТТБТАД-ийн 4.1.1	Төмөр замын вагон, цистерн бусад төрлийн тээврийн хэрэгслийн ачааг механикжсан аргаар тогтоосон хугацаанд буулгадаг	0	10	
113	ЭХТТБТАД-ийн 4.1.3	Түлшийг төмөр замын болон авто пүүгээр жинлэдэг	0	5	
114	ЭХТТБТАД-ийн 4.1.8	Түлш дамжуулах, буулгах, гэсгээх байгууламжуудын хяналтын аппарат хэмжих хэрэгсэл, автомат ба алсын удирдлага, технологийн хамгаалалт, хориг, дохиолол, диспетчерийн ба технологийн удирдлагын хэрэгслүүд нь бүрэн бүтэн бөгөөд графикийн дагуу шалгалт хийгдсэн	0	10	
115	ЭХТТБТАД-ийн 4.1.9	Түлшийг гэсгээх байгууламж, механик сийрэгжүүлэгч, вагон доргиогчоор тоноглогдсон	0	5	
116	ЭХТТБТАД-ийн 4.1.17	Түлш дамжуулах механизмуудыг удирдлагын төв шитнээс автоматаар буюу алсаас удирддаг	0	5	
117	ЭХТТБТАД-ийн 4.1.1	Түлш дамжуулах системийн анхааруулах дохиоллын систем, тормозлох байгууламжийн ажиллагаа хэвийн, хамгаалах хашлагатай	0	10	
118	ЭХТТБТАД-ийн 4.1.23	Түлш дамжуулах системийн буух хоолой, бутлагч болон түлшний дамжлагын бусад механизмуудын нягтруулга, дамжлагын тууз ба бул цэвэрлэгч, займчин тэжээгчийн ажлын хэсгүүд, тоос сорох ба баригч төхөөрөмжүүд нь бүрэн бүтэн, нягтруулга битүүмжлэл сайтай	0	5	
119	ЦСДШСДМТАУААД-ийн 3.1	Түлш дамжуулах системд аспирацийн төхөөрөмж суурилагдсан, ажиллагаа хэвийн	0	10	
120	ЦСДШСДМТАУААД-ийн 3.1	Тоосжилтын хэмжээ нь аюулгүй ажиллагааны дүрэмийн шаардлагад нийцсэн	0	10	
НИЙТ ОНОО			0	1280	0

БАТАЛГААЖУУЛАЛТ					
Хяналтын чиглэл, албан тушаалын нэр		Хяналтын чиглэл, албан тушаалын нэр	Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтан		

<i>/ овог, нэр/</i>	<i>/ овог, нэр/</i>	<i>/ овог, нэр/</i>
<i>/ гарын үсэг, тэмдэг/</i>	<i>/ гарын үсэг, тэмдэг/</i>	<i>/ гарын үсэг, тамга/</i>

Тайлбар: